

## ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР БА АМЬЖИРГААНЫ ЧАДАВХИ

### Д. Сувдаа

Эдийн засгийн магистр, МУИС-ЭЗСийн багш

*Нийгмээс хүн амын дунд хуваарилагдаж буй орлогын хуваарилалт нь хүн амын дунд баян хоосны ялгааг зөөлрүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангах зорилготой бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нэг хэрэгсэл нь хүн амын орлогын албан татвар байдаг.*

*Хүн амын орлогын албан татварын бодлого, хэрэгжилт нь хүн амын мөнгөн орлого, зарлага, ажил эрхлэлттэй салшгүй холбоотой. Манай улсын хувьд хүн амын мөнгөн орлого бага, ядуурал өргөн давхаргыг хамарч байгаа нь дээрх бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Хүн амын дунд орлого хуваарилан нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх татварын бодлогын хэрэгжилт сул байх нь эргээд хүн амын аж амьдралд онцгой нөлөөтэй байх болно.*

*Ийм ч учраас энэхүү ажилд, дээрх үзүүлэлтүүдийн хоорондын харилцан уялдаа, бодит байдал ямар байгааг статистик тоо, баримтууд дээр судлан, манай улсад хэрэглэгдэж буй татварын бодлого, хэрэгжилтийг хүн амын амьжиргаанд аль болох бага дарамт үзүүлэх талаас нь анхааран сайжруулах хэрэгтэй талаар дүгнэлт, зөвлөмжийг гаргасан болно.*

Албан татварын агуулга нь хувь хүн ч бай, албан байгууллага ч бай тухайн нийгэмд оруулж буй хувь нэмрээр тодорхойлогдоно. Нөгөө талаас албан татварын нийгмийн үүрэг нь нийгмийн гишүүдийн амьжиргааны түвшинг ерөнхийд нь хангахад чиглэгддэг.

Зах зээлийн механизмын нийтээр хүлээн зөвшөөрсөн нэг сул тал нь орлогыг нийгэм хүлээн авахуйцаар, улс үндэстний нийтлэг ашиг сонирхолд нийцэхүйцээр хуваарилж чаддаггүйд оршино. Орлого хуваарилалтын тэнцвэргүй байдлыг засахгүйгээр нийгмийн тогтвортой хөгжлийг хангах боломжгүй юм. Иймд хүмүүсийн хооронд орлого хуваарилан баян хоосны ялгааг зөөлрүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангах нэг хэрэгсэл нь хүн амын орлогын албан татвар болдог.

Хүн амын орлогын албан татвар нь шууд татварын нэг төрөл бөгөөд хувь хүний ашиг орлогоос нь шууд, ил тодоор төлөгддөг учир түүний бүх шинж чанар татвар төлөгчдөд шууд мэдрэгдэж, эерэг ба сөрөг нөлөөлөл нь бусад татварынхаас нэлээд хурц илэрдэг.

Манай орны төсвийн орлогод татварын орлого 75 орчим хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд татварын орлогын бүтцэд нэлээд өөрчлөлт гарч, шууд татварын хувийн жин буурч, шууд бус татварын хувийн жин өсөн нэмэгдэж байна (Хүснэгт1).

**Хүснэгт 1. Монгол улсын татварын орлогын бүтэц ( хувиар)**

Татварын нэр төрөл		1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001
Орлогын албан татвар	ААН, байгууллагын	52.5	41.3	41.0	35.1	31.5	20.3	14.6	18.4	13.9
	<b>Хүн амын</b>	<b>2.2</b>	<b>3.2</b>	<b>5.0</b>	<b>5.2</b>	<b>4.7</b>	<b>6.6</b>	<b>6.9</b>	<b>5.7</b>	<b>6.5</b>
Онцгой албан татвар		12.0	13.4	8.1	9.0	12.5	15.9	14.7	15.7	15.5
Гаалийн татвар		12.8	16.8	9.1	11.2	1.0	1.0	5.0	8.6	8.6
НӨАТ татвар)	(худалдааны даатгалын	13.8	13.6	15.4	16.8	29.9	29.9	33.3	29.2	33.2
Нийгмийн шимтгэл		3.5	7.5	14.9	14.6	16.9	16.9	16.4	15.1	14.4
Бусад төлбөр хураамж		3.2	4.2	6.5	8.1	7.5	9.4	9.1	7.3	7.9
Бүгд		100	100	100	100	100	100	100	100	100

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэл-2000, 2001 он

Дээрхи тоо баримтаас үзэхэд хүн амын орлогын албан татварын нийт татварын орлогод эзлэх хувийн жин харьцангуй бага байгаа нь хүн амын амьжиргааны түвшин доогуур, ядуурал их байгаатай, мөн хувиараа бизнес эрхлэгчдийг татварт бүрэн хамруулж, хурааж чадахгүй байгаа, далд эдийн засаг нилээд хэмжээгээр (ДНБ-ий 30 хувьтай тэнцүү) үйлчилж байгаа, татварын талаархи мэдлэг, сурталчилгаа хангалтгүй байгаатай холбоотой юм.

Манай улсын хүн амын орлогын татварын дотор *хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого* нь орлогын гол эх үүсвэр болж байна. Үүнд: үндсэн болон нэмэгдэл цалин, ажлын үр дүнтэй холбоотой бүх төрлийн шагнал, урамшуулал, нэмэгдэл, гэрээ хэлцлээр урт богино хугацаанд гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хөлсийг тэдгээрийн хэлбэр, нэр, төлбөрийн хэрэгслийн ялгааг үл харгалзан татварт хамруулахаар заасан байдаг.

Хүн амын орлогын бас нэг томоохон эх үүсвэр нь *хувиараа аж ахуй эрхэлсний орлого* юм. Энэ орлогод татвар ногдуулахтай холбоотой 2 хууль хэрэгжиж байна.

Үүний нэг нь "Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хууль" юм. Уг хуулийг 1994 оноос мөрдөж эхэлсэн. Энэ татвар нь ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогод ногдуулж байгаа тогтмол татвар юм.

Олон улсын хэмжээнд тогтмол татварыг татвар төлөгчдийг татвар төлж сурах, татварын адил тэгш байх зарчмыг хангах, татварын суурийг өргөжүүлэх, жижиг татвар төлөгчдийг албан бус сектороос албан секторт оруулж ирэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж үздэг. Ийм татварыг хөгжиж буй орнууд өргөн хэрэглэдэг ба Франц, АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад ч мөн хэрэглэдэг байна.

Хүн амын орлогын албан татварын хуулиар зохицуулагдаж буй дараагийн нэг орлогын төрөл нь хувийн *мал бүхий иргэний орлого* буюу малчдын орлогын татвар юм. Энэ орлогод татвар ногдуулах асуудал манай улсын эдийн засгийн голлох салбар болох мал аж ахуйн татварын бодлоготой салшгүй холбоотой.

Манайд өрхийн ам бүлийн тооноос хамаарсан хөнгөлөлттэй, малын толгой тутамд тогтоосон хэмжээтэй, татварын уламжлалт хэлбэрээр татвар ногдуулж байна.

Одоогоор Монгол улсад мөрдөгдөж байгаа хуулиар, татвар тооцох орлогод дараах хувиар татвар ногдуулж байна.

Татвар ногдох орлого /сарын /	Татварын хувь хэмжээ
0-200.000	10%
200.001-400.000	(20.000+200.001-давсан орлогын 20%)
400.001-дээш	(60.000+400.001-давсан орлогын 40%)

Дээрхи татварын хувь хэмжээ, татвар ногдох орлогоос үзэхэд 20 хувь, 40 хувь буюу сүүлчийн 2 шатлал бараг практик дээр хэрэглэгдэхгүй байна гэж хэлж болно. Хамгийн энгийн жишээ дурьдвал дээрх шатлалаар татвар тооцох орлогын үндсэн хэлбэр болох цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах сарын цэвэр орлогын хэмжээ төрийн өмчийн болон төсөвт байгууллага, хувийн хэвшлийн аль ч салбарын ажиллагсдын хувьд 200.000 төгрөгт хүрэхгүй байгаа нь хэнд ч ил байна.

Ийнхүү хүн амын орлогын албан татварын бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хүн амын амьжиргааны түвшин, мөнгөн орлого, зарлага, ажил эрхлэлттэй салшгүй холбоотой. Хүн амын дунд орлого хуваарилан баян хоосны ялгааг зөөлрүүлэх, нийгмийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй татварын бодлогын хэрэгжилт сул байх нь эргээд хүн амын аж амьдралд онцгой нөлөөтэй байх болно.

1990 оноос өмнө хүн бүр улсын секторт хөдөлмөр эрхлэн тогтмол цалин авч үндсэндээ ажилүйдэл, ядуурал үгүй байв. Харин улсын үйлдвэр, аж ахуйн газрыг хувьчлан, нэгдэл хоршоодыг тарааснаар ажилгүйдэл эрс өсч, хүмүүс хөдөлмөр эрхлэх болсноор албан бус секторт ажиллах хүрээ нэмэгджээ. Гэтэл энэ нь голдуу улирлын шинж чанартай байсан тул тэдний амьдрал сайжрах бус, улам эмзэг, баталгаагүй болов. Ийнхүү хүн амын бодит орлого жилээс жилд буурч байгаа нь эдийн засагт нийт эрэлтийг багасгаж, улмаар хүн амын хэрэглээний түвшин эрс буурах болсон нь эдийн засгийн үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхөд хүргээд байна.

Хүн амын бодит орлого, худалдан авах чадварыг жилээс жилд бууруулахгүйн тулд инфляцийн түвшингийн өсөлтөөс цалингийн өсөлтийг илүү хурдацтай өсгөх зарчмыг баримтлах нь чухал. Энэ зарчим сүүлийн жилүүдэд алдагдаж ирснийг дараах тоо, баримтаас харж болно (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. Инфляци, хүн амын цалингийн түвшний өөрчлөлт, 1996-2001 онд**

Үзүүлэлт (%)	Он	
	1996-2000	2000-2001
Инфляцийн түвшин	40	14-16
Цалин хөлсний түвшин	30	5-6
<b>Бодит орлогын бууралт</b>	<b>10</b>	<b>9-10</b>

*Эх сурвалж: Д.Намжил, "Өрхийн орлого, өөрчлөлт, чиг хандлага"*

Мөн нэг өрхийн сарын мөнгөн орлого, зарлагыг авч үзье (Хүснэгт 4)

**Хүснэгт 4. Өрхийн аж ахуйн орлого, зарлагын бүтэц, /Өрхийн сарын дундаж орлого, зарлаг/, оны үнээр, 1998-2001**


Орлогын төрөл	1998 он		1999 он		2000 он		2001 он	
	Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн	Хувь
<b>Мөнгөн орлого -Бүгд</b>	<b>66217</b>	<b>100</b>	<b>67426</b>	<b>100</b>	<b>101376</b>	<b>100</b>	<b>102133</b>	<b>100</b>
Үүнээс:								
- Цалин	22860	34.5	23314	34.6	31004	30.6	32459	31.8
- Тэтгэвэр, тэтгэмж	5739	8.7	6014	8.9	7916	7.8	8929	8.7
- Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого*	19022	28.8	19694	29.2	19455	19.2	13678	13.4
- Арилжаа, наймаа	7801	11.8	8084	12.0	12815	12.6	18097	17.7
- Мөнгөн тусламж, бэлэг	1200	1.8	1881	2.8	2000	2.0	2145	2.1
- Зээл	3430	5.2	2526	3.7	1969	1.9	1930	1.9
- Бусад **	6168	9.2	5923	8.8	26217	25.9	24895	24.4
<b>Мөнгөн зарлага-Бүгд</b>	<b>68639</b>	<b>100</b>	<b>71804</b>	<b>100</b>	<b>101375</b>	<b>100</b>	<b>102133</b>	<b>100</b>
Үүнээс:								
- Хүнсний зүйлийн зарлага	29327	42.7	29487	41.1	42269	41.6	43417	42.5
- Хүнсний бус барааны зарлага	22754	33.2	24155	33.6	34256	33.8	29996	29.3
-Таваарын бус мөнгөн зарлага	16249	23.6	17699	24.6	24698	24.4	28452	27.9
Үүнээс: Татвар, хураамж	2352	14.5	3193	18.1	2257	9.1	1043	3.7
- Хадгаламж	309	0.5	463	0.6	152	0.2	268	0.3


Эх үүсвэр: *ҮСГ, МУ-ын статистикийн эмхтгэл, 2001*

\*- Өрхийн хувийн аж ахуйн хэрэглээг хасч тооцов.

\*\* - Бусад орлогод оюуны өмчийн орлого, патентын орлого, хадгаламжийн хүү болон тодорхой бус орлого (орлого, зарлагын зөрүү) орсон болно.

Хүснэгтээс харахад, мөнгөн орлогын 30 гаруй хувь нь цалин хөлснөөс, мөн тэр хэмжээний орлого, үйлвэрлэл үйлчилгээ, арилжаа наймаанаас орох болжээ. Зураг 1,2-т 2001 оны байдлаарх өрхийн орлого, зарлагын бүтцийг үзүүлэв.





Зураг 2-оос харахад, хүн амын орлогын дийлэнх нь хэрэглээнд зарцуулагдаж хөрөнгө мөнгөө өсгөх, хуримтлуулах боломжгүй байгаа нь харагдаж байна.

Манай орны хүн амын дийлэнх хэсгийн орлого ерөнхийдөө бага, шилжилтийн нөхцөлд хэрэглээний зүйлийн үнэ огцом өссөн, нийлүүлэлт нь харьцангуй сайжирсан явдал өрхийн зарлагын бүтцэд хүнсний ба хүнсний бус барааны зарлага давамгайлах нөхцлийг бүрдүүлсэн гэж болно.

Дээрх баримтууд нь манай орны хүн амын ядуурал харьцангуй ихэсч буйг тодорхой хэмжээгээр баталж байгаа юм. 1998 онд ҮСГ-аас хийсэн Амьжиргааны Түвшний Түүвэр Судалгаагаар хүн амын 35.6% нь ядуу, нэн ядуу категорид хамрагдаж байна гэсэн тооцоо гарсан байна (Хүснэгт 5).

**Хүснэгт 5. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүд /1995 ба 1998 он/**

Үзүүлэлт	Амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь		Ядуу хүмүүсийн тоо /мянгаар/		Ядуурлын гүнзгийрэлт (%)		Ядуурлын туйлдаг	
	1995	1998	1995	1998	1995	1998	1995	1998
Улсын хэмжээнд	36.3	35.6	820.7	862.9	10.9	11.7	4.8	5.6
Хот суурин газарт	38.5	39.4	470.5	493.4	12.2	13.9	5.7	7.1
Улаанбаатар т	35.1	34.1	214.1	221.3	10.4	13.0	4.5	7.4
Бусад хотуудад	41.9	45.2	256.5	272.1				
Хөдөө нутагт	33.1	32.6	350.1	369.5	8.9	9.8	3.6	4.4

Эх сурвалж: ҮСГ, Хүн амын Амьжиргааны Түвшний Түүвэр Судалгаа, 1998

Тайлбар:

- "Гүнзгийрэлт" нь ядуу хүний дундаж орлого амьжиргааны баталгаажих доод түвшингээс хир доош орсныг үзүүлнэ.
- "Туйлдаг" нь ядуу хүмүүсийн доторх орлогын хувиарлалтын байдлыг авч үзэхдээ ядуурлын түвшинээс хамгийн доогуур түвшинд байгаа хүмүүсийн байдлыг илүүтэй харуулна.

Эцэст нь дүгнэхэд манай улсын хувьд төрийн зохицуулалтын арга хэрэгслийн нэг болох татварын бодлогыг төсвийн орлогыг бүрдүүлэхээсээ илүү хүн амын

амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах хөшүүрэг болгох талаас нь анхаарч сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

#### **Ном зүй:**

---

1. Л.Пүрэвдорж, "Хувийн орлогын албан татвар" - УБ, 2000 он
2. Michael J.Boskin Charles E.Mclure, "World tax reform ", San Francisko California , 1990 year /Case studies Developed & Developing Countries /
3. Bernard Jones "Financial Management in the Public Sector", Great Britian, Cambridge, 1996 year
4. М.В Карп "Налоговые менежмент", Москва 2001 г
5. И.Г Русаковой, В. А Кашина, "Налоги и налогообложение", Москва, 1998 г
6. NSO, "Participatory living Standards Assessment 2000 year"
7. "Үндэсний татварын алба, 10 жил", УБ, 2001 он
8. Үндэсний Татварын Ерөнхий Газрын тайлан, УБ, 1 995-2001 он
9. Монголын хүний хэгжлийн илтгэл, УБ, 1997, 2000 он
10. ҮСГ, Статистикийн эмхтгэл, УБ 1993-2001 он
11. Монгол банкны жилийн тайлан, УБ, 1998-2001 он
12. Д.Намжил, "Макро эдийн засгийн санхүү мөнгөний бодлого", Уб., 2000